

БАТЛАВ
"ДЦС-4" ТӨХК-ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



2021 он 5 дугаар сарын 27-ны өдөр

БАТЛАВ
"ХҮРЭН САЙР" ХХК-ийн
ЗАХИРАЛ Д.БЯМБАЖАВ



№ 4/2021-219

Улаанбаатар хот

ХАЯГДАЛ ТӨМӨР ХУДАЛДАХ ГЭРЭЭ

Энэхүү гэрээг нэг талаас "ДЦС-4" ТӨХК-г төлөөлж БҮЭД захирал Б.Сандуйжав /цаашид худалдагч гэх/ нөгөө талаас "ХҮРЭН САЙР" ХХК-НИЙ захирал Д.Бямбажав цаашид худалдан авагч гэх/ нар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20, 31-р зүйлийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь "ХҮРЭН САЙР" ХХК нь ашиглагдахгүй болсон 2Т трансформаторуудыг худалдан авахад ачих, тээвэрлэх ба тээврийн хэрэгсэлийг орж гарахад хяналт тавих төлбөрийг цаг хугацаанд нь гэрээнд заасны дагуу төлөх, гэрээт хугацаа эхлэх, дуусах явцтай холбоотой үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажсанаар гэрээ хууль зүйн хүчин төгөлдөр болж, худалдах худалдан авах ажиллагаа эхлэнэ.
- 2.2 Худалдах ба худалдан авах ажиллагаа нь 2021 оны 05-р сарын 27-наас 2021 оны 06-р сарын 11-ний өдөр хүртэл 14 хоногийн хугацаатай явагдана.
- 2.3 Хоёр тал харилцан тохиролцсны үндсэн дээр гэрээний гүйцэтгэлийн хугацааг сунгаж болно.

Гурав. Төлбөр тооцоо

- 3.1 Хаягдал 2Т трансформаторыг 35,000,000 төгрөг байхаар /гучин таван сая/ байхаар талууд харилцан тохиролцов.
- 3.2 Худалдан авагч нь төлбөрийг ДЦС-4 ТӨХК-н дансанд бүрэн төлж өргөх зөөх, тээвэрлэх тээврийн хэрэгсэл орох зөвшөөрөл авна. .

Дөрөв. Худалдан авагчийн үүрэг

- 4.1 Худалдан авагч нь Тээврийн хэрэгсэлийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллана. Замын хөдөлгөөний дүрмийг чанд сахиж ажиллана.
- 4.2 Худалдан авагч нь харуулын постоор зөвшөөрлийн дагуу орж, гарахдаа станцын нутаг дэвсгэрт дотоод журмыг мөрдөнө.
- 4.3 Худалдан авагч нь ачилт хийж дууссны дараа трансформаторуудын ойр орчмыг цэвэрлэж өөрсдийн зардлаар хог хаягдлын тээвэрлэнэ.

Тав. Худалдагчийн үүрэг

- 5.1 Худалдагч нь худалдан авагч талын харуулаар орох гарахад хяналт тавьж 2Т трансформаторыг тээвэрлэх нөхцлийг хангаж ажиллана.
- 5.2 Станцын БМА-ны борлуулалтын мэргэжилтэн ачилтанд тогтмол хяналт тавьж ачилтыг зохион байгуулна
- 5.3 Харуулын постоор нэвтрэх тээврийн хэрэгсэл, ажиллах хүчний зөвшөөрлийг хууль журмын дагуу хүндрэл чирэгдэлгүй шуурхай зохион байгуулах .

Зургаа. Хоёр талын эрх

худалдагч :

худалдан авагч:

- 6.1 Гэрээнд заасны дагуу худалдан авах ажиллагаанд хоёр талын эрх бүхий хүмүүс тухай бүр нь хянаж баталгаажуулж байна.
- 6.2 Гэрээнд зааснаас өөр үйлдэл хийх буюу эд зүйлийг эвдсэн, хулгайлсан, архи уусан зэрэг бусад хэв журмын зөрчил гаргасан тохилдолд гэрээг цуцлах эрхтэй.
- 6.3 Техник Хяналтын Хэлтсийн шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, эсэргүүцсэн тохиолдолд гэрээг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Долоо. Бусад зүйл

- 7.1 Талууд энэхүү гэрээг Монгол хэл дээр 3% үйлдэж захиалагч тал 1% -ыг гүйцэтгэгч тал 2% -ийг хадгалах ба тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй.
- 7.2 Энэхүү гэрээг хэрэгжүүлэх болон хүчин төгөлдөр байх хугацаанд гарч болох бүх маргаан зөрчил зэргийг харилцан тохиролцож шийдэх ба үл тохиролцсон тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Худалдагч талыг төлөөлж:

"ДЦС-4" ТӨХК-ИЙНТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ БӨГӨӨД
ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
.....Б.ГАНХУЯГ
/2021 ОН...САРЫН...ӨДӨР/

БҮЭД ЗАХИРАЛ.....Б.САНДУЙЖАВ
/2021 ОН...САРЫН...ӨДӨР/

"ДЦС-4" ТӨХК-ИЙН
БМА-НЫ ДАРГАС.АЛТАНХУЯГ
/2021 ОН...САРЫН...ӨДӨР/

"ДЦС-4" ТӨХК-НИЙ
СБА-ИЙН ДАРГАД.ТӨМӨРТОГОО
/2021 ОН...САРЫН...ӨДӨР/

ХУУЛИЙН ЗӨВЛӨХЧ.БЯМБАСҮРЭН
/2021 ОН...САРЫН...ӨДӨР/

ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭНС.ДОНИД
/2021 ОН...САРЫН...ӨДӨР/

Монгол улс,
16100 Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, 20 дугаар хороо
"ДЦС-4" ТӨХК
Утас: 70170783
ДАНС:ДЦС- 4 ТӨХК КАСС
5038008126

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН
Худалдан авагч талыг төлөөлж:

"ХҮРЭН САЙР"ХХК- ИЙН
ЗАХИРАЛ Д.БЯМБАЖАВ
.....
2021 ОНЫ...САРЫН...ӨДӨР



ХОЁР ТАЛЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ

Худалдан авагчийн хууль ёсны хаяг, утас, факс,
БЗД -ийн 4-р хороо 15-Р хороолол 3/48 тоот
Утас: 95959968

худалдагч :

худалдан авагч: